



ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

МАХНЫ МАШИН

ЗАГВАР: RMM23PW11



Хэрэглэхээс өмнө зааварчилгаатай сайтар танилцана уу

Баталгаат засварын хуудас нь худалдан авсан барааны төлбөрийн баримтын хамт хүчинтэй тул анхаарч, хадгалахыг зөвлөж байна

Rotenko брэндийн махны машиныг сонгосонд баярлалаа. Гарын авлагыг хэрэглэгч та бүхэнд бүтээгдэхүүнийг зөв, бүрэн гүйцэд ашиглахад туслах үүднээс бэлтгэв.

Махны машиныг ашиглахын өмнө гарын авлагатай танилцана уу!

Энэхүү гарын авлага нь таны цаашдын хэрэглээний явцад байнга туслах тул хадгална уу!

Бүтээгдэхүүнийг бусдад дамжуулахаар бол гарын авлагыг хамтад нь өгнө үү!

## I. АНХААРУУЛГА


- Энэхүү махны машин нь ахуйн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн болно. Бусад зорилгоор ашиглахад тохиромжгүй.
- Нарны шууд тусгал болон нойтон, чийгтэй газар хадгалж болохгүй. Хэрэв дотор эд анги чийгтэй байвал даруй салгаж, гүйцэд хатсаны дараа хэрэглэнэ.
- Дагалдах хэрэгслийг цэвэрлэх тохиолдолд махны машиныг салгаарай!
- Өрөөнөөс гарахдаа махны машиныг заавал унтраах ёстой. Хүүхэд байгаа газар хэрэглэвэл хараа хяналт тавих хэрэгтэй.
- Махны машины гэмтлийг сайтар шалгаж байх, хэрэв эвдрэлтэй байвал ашиглаж болохгүй.
- Хэрэв махны машин эвдэрвэл өөрөө засах гэж оролдох хэрэггүй, даруй мэргэжлийн хүнд хандана уу!
- Зөвхөн өөрийнх нь дагалдах хэрэгслийг ашиглана. Орлуулах хэрэгсэл ашиглахгүй байхыг зөвлөж байна.
- **Машиндах** махаа гараар хийхийг хатуу хориглоно. Зөвхөн зориулалтын мах шахагчийг хэрэглээрэй!
- Яс, самар, цагаан гаа гэх мэт хатуу болон ширхэгтэй хүнсийг машиндаж болохгүй.

- Махны машин **ажиллаж** байх үед “Reverse” /Урвуу/ товчлуурыг ашиглах хориотой.
- Махны машин бүрэн зогсох хүртэл 1 минут хүлээх хэрэгтэй. Эс бөгөөс энэ нь хэвийн бус дуу чимээ үүсгэдэг. Энэ нь **машиныг** гэмтээх, мөн хэрэглэгчдэд айdas төрүүлж болзошгүй юм.
- Хэрэглэсний дараа бага зэрэг үлдэгдэл махны машины толгойд үлддэг. Энэ бол хэвийн үзэгдэл бөгөөд үүнийг цэвэрлэх хэрэгтэй.
- Хэрэв тэжээлийн утас гэмтсэн бол засвар үйлчилгээний төвд хандаарай!
- Хүүхэд **хүрэхээс** сэргийлж уут, картон эсвэл **хөөсөнцөр** хайрцагт хадгалаарай!

#### **АНХ ХЭРЭГЛЭХДЭЭ ДООРХ САNUУЛГЫГ АНХААРНА УУ.**

- Шошго дээр заасан хүчдэл нь хэрэглэгчийн гэрийн үндсэн хүчдэлтэй тохирч байгаа эсэхийг шалгаарай!
- “Off” товчлуурыг дарсны дараа цахилгаанд залгах хэрэгтэй.

## II. ЭД АНГИ



- |                           |                           |
|---------------------------|---------------------------|
| A. Max шахагч             | L. Өрмөн гол              |
| B. Тавиур                 | M. Хутга                  |
| C. Толгой                 | N. Бүдүүн шүүр            |
| <b>D. Нээх товчлуур</b>   | O. Бэхлэх цагариг         |
| E. Ухраах товчлуур        | P. Хутганы туугаарлагч    |
| F. Асааж унтраах товчлуур | Q. Зайдас хийгч           |
| G. Их бие                 | R. Кебаб хийх хэрэгсэл 1. |
| J. Нарийн шүүр            | S. Кебаб хийх хэрэгсэл 2. |

### III. АШИГЛАХ ЗААВАР

Махны машиныг зурагт үзүүлсэн байдлаар угсарч , ажиллуулна.

#### Махны машиныг угсрах




1. Эд ангиудыг зурагт үзүүлсэн байдлаар толгой уруу хийнэ. Өрмөн голыг толгой уруу хийхдээ төгсгөл хэсгийг нь эхэлж орохоор байрлуулна  
Шүүрийн хэмжээг дурын байдлаар /хутгыг урд нь байхаар/ сонгоно. Бэхлэх цагаригийг хийн сайтар эргүүлнэ.



2. Толгойн хэсгийг их биед суурьлуулна.
3. Тавиурыг толгойн дээд хэсэгт оруулна.
4. Махны машин ажиллагаанд бэлэн болно.



**Санамж:** Машиндахын өмнө махыг 10 см урт 2 см зузаантай хэрчиж, ясны хэлтэрхий, хатуу биет зэргээс гүйцэд цэвэрлэнэ.



/ХӨЛДҮҮ MAX МАШИНДАЖ БОЛОХГҮЙ/

Тавиур дээр машиндах маахаа тавсны дараа асаах товчлуур дээр асааж, махыг толгойн хэсэг рүү шахагчийг ашиглан бага багаар зөөлөн дарж оруулна.

## Зайдас хийгчийг угсрах



1. Махаа машиндана.
5. Зайдас хийгчийг зурагт үзүүлсэн дарааллаар хийнэ. Өрмөн голыг толгой уруу хийхдээ төгсгөл хэсгийг нь эхэлж орохоор байрлуулна  
Тусгаарлагчийг хийхдээ толгойн хэсэгт гүйцэд орсон эсэхийг шалгана уу.
3. Гүйцэд тоноглогдсон толгойн хэсгийг их биед оруулна.
4. Тавиурыг толгойн дээр хэсэгт байрлуулна.
5. Махны машин нь ажиллагаанд бэлэн болно.

## Зайдас хийх:



Бүх орцыг тавиур дээр тавина. Шахагчийг ашиглан толгойн хэсэг рүү зөөлөн дарж оруулна.



Зайдасны хальсыг бүлээн усанд 10 минут орчим дэвтээсний дараа зайдас хийгчийн хошуунд углана. Махны машиныг ажиллуулна. Хэрэв зайдасны хальс зайдас хийгчийн хоолойд тээглэсэн бол бага зэрэг усаар чийглэнэ.



## Кебаб хийгчийг угсрах

1. Угсрахдаа зурагт үзүүлсэн дарааллаар хийнэ. Өрмөн голыг толгой уруу хийхдээ төгсгөл хэсгийг нь эхэлж орохоор байрлуулна



Кебаб хийх хэрэгслүүдийг өрмөн голын урд хийн бэхлэх цагаригийг сайтар чангалаа.



2. Гүйцэд тоноглогдсон толгойн хэсгийг их бие рүү хийнэ.
3. Тавиурыг толгойн хэсэг дээр байрлуулна.
4. Махны машин ажиллагаанд бэлэн болно.



## Кебаб хийх:

Тавиур дээр бүх орцуудыг тавина. Махны уртыг өөрийн хүссэн хэмжээнд тохицуулан тайрч болно.

#### IV. ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ

- Махны машиныг салгаж, сайтар хөрсний дараа цэвэрлэнэ.
- Нээх товчлуурыг даран толгойн хэсгийг цагийн зүүний дагуу эргүүлэн их биё, тавиур зэргийг салгана.
- Толгойн хэсгийн бэхлэх цагаригийг суллан доторх бүх эд ангиудыг гарган цэвэрлэнэ. Аяга таваг угаагч машинд хийхээс зайлсхий.
- Цэвэрлэгээ хийхдээ усаар сайтар зайлж угаасны дараа хуурай даавуугаар арчина.
- Төрөл бүрийн зүлгүүр ашиглаж болохгүй.
- Хурц цэвэрлэгээний бодис бүү ашигла!
- Хутга болон шүүр, өрмөн гол зэргийг тоскоор тослож болно.

#### Санамж:

- Махны машинд яс болон бусад хатуу биет орсон тохиолдолд автоматаар зогсдог. Энэ үед үргэлжлүүлэн ажиллуулах, хүчээр асаах зэргээс зайлсхийж, **Reverse** буюу буцаах товчлуурыг даран хатуу биетийг гаргасны дараа ажиллуулна уу.
- Буцаах товчийг дарсны дараа ойролцоогоор 4 секундийн дараа ажиллаж эхлэх ба нэг даралтаар 5 секундийн турш ажиллаад автоматаар унтрахыг анхаарна уу.



Энэхүү төхөөрөмж нь Европын стандартын 2014/35/EU, 2014/30/EC, 2009/125/EC захирамжуудад нийцдэг.



Энэхүү бүтээгдэхүүний материалыг дахин боловсруулах боломжтой тул уг бүтээгдэхүүний ашиглалтын хугацаа дуусах үед ердийн ахуйн хог хаягдалд хаяж болохгүй, харин цахилгааны болон электрон төхөөрөмжийг дахин боловсруулах цэг дээр хаях ёстой. Та хуучин төхөөрөмжийг дахин ашиглах, дахин боловсруулах, ашиглах замаар байгаль орчныг хамгаалахад чухал хувь нэмэр оруулаарай.